



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/МЖ

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” хэг/595 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга )

Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Э.Бадамгэрэл (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Д.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Хүний эрх, авлига, ашиг сонирхлын зөрчлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Х.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: А.Отгонцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга )

2. Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, улсын үйлдвэрийн газарт хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж томилогдсон иргэнийг олж тогтоон, дүнг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0252

D:My Doc. Zahiramj. Zasag darga